*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БАЯРМӨНХИЙН БАТТҮВШИНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулах, арга зүйгээр хангах | хэрэгжилтийн хувь | 95% | Хэрэгжилтийн хувь 97% | Бүх нийтэд эрх зүйн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нутгийн удирдлагын ордон, Зэст багийн нэгдсэн байр, Захиргааны 4-р байруудад эрх зүйн хөтөч нарыг ажиллуулж, иргэд хууль зүйн туслалцаа мэдээлэл авахад шаардлагатай, техник тоног төхөөрөмж, гарын авлагаар бүрэн хангаж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл, туслалцаа үзүүлэн ажиллаж байна.<br>Эрх зүйн хөтөч нар тайлант хугацаанд 13 сэдвээр 42 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2164 хүн хамрагдаж, 1327 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 1063 хуулийн постер, 69 зурагт хуудас, 34 гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, “Номин” телевизтэй хамтран “Хуулийн цаг” 29 удаагийн нэвтрүүлэг, богино хэмжээний видео 27, нийт 63 нэвтрүүлэг, | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | видео бэлтгэж телевиз болон цахим хэлбэрээр иргэдэд сурталчилж ажилласан. Сургалт сурталчилгаа, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 86489 хүн хамрагдаж, хөтөлбөрийн хэрэгжилт 100%-тай байна. | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Эрх зүйн хөтөч ухуулагч нарыг удирдлага арга зүйгээр хангах, ажлын үр дүнг тооцох, чадавхижуулах ажлыг хэрэгжүүлэх | үр дүнгийн үзүүлэлт | Сургалт сурталчилгаа, зөвлөгөө мэдээлэл өгсөн тоо 1176 | Удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна. | Хууль сурталчлах, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх зөвлөгөө мэдээллээр хангах чиг үүрэг бүхий эрх зүйч мэргэжилтэй 6 эрх зүйн хөтчийг орон нутгийн төсвөөс цалинжуулж гэрээ байгуулан ажиллуулж байгаа бөгөөд хэлтсээс удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажлын үр дүнг тооцож ажиллаж байна. Эрх зүйн хөтчийг чадавхижуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж, бусад байгууллагаас цахимаар болон танхимаар зохион байгуулсан 6 сургалтад хамруулсан. Хөтчийн ажлын дэвтэр болон тайлан гаргах загварыг батлан 7 хоног бүр хийсэн ажлын мэдээг авч ажлын үр дүнг үндэслэн урамшууллыг олгож байна.<br>Тайлант хугацаанд эрх зүйн хөтөч нар 1327 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |
| 3. | Арга хэмжээ 1.3.<br>Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангаж, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах | туслалцаа үзүүлсэн иргэдийн тоо | 103 | Төвд хандсан иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна. | Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тогтворжуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсөвт төвийн үйл ажиллагаанд шаардагдах 8 сая төгрөгийг тусган батлуулж, дэмжлэг үзүүлсэн.<br>Төвийг энэ оноос Зэст багийн нэгдсэн байранд шинэ ажлын | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байраар хангаж иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх, мөн ганцаарчлан уулзах өрөөг тохижуулан байрны урсгал зардал, утас болон интернетийн зардлыг ЗДТГ-аас бүрэн хариуцдаг.<br>Хууль, эрх зүйн хэлтсийн даргаас өмгөөлөгчийн үйл ажиллагаа, санал хүсэлтийн талаарх мэдээллийг 7 хоног бүр авч, удирдлага арга зүйгээр ханган аймгийн ЗДТГ болон хууль, эрх зүйн хэлтсээс явуулж буй үйл ажиллагаанд хамруулан дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд 43 хүнд холбогдох 42 эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлснээс 34 хүнд холбогдох 33 хэргийг эцэслэн шийдвэрлүүлсэн. Мөн туслалцааны төвд хандаж ирсэн 250 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Хууль тогтоомжийн лавлагааны санг бүрдүүлж, иргэд байгууллагад лавлагаа мэдээллээр үйлчлэх ажлыг зохион байгуулах | - лавлагааны сангийн баяжилт /актын тоо/<br>- үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 1024 | Санг бүрдүүлж, иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна. | Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавламжийн санд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, УИХ-ын тогтоол, Монгол улсын олон улсын гэрээ, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын дээд шүүхийн тогтоол, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр, ЗГ-ын агентлагийн даргын тушаал, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж нийт 46394 хууль тогтоомжийн актыг гар болон цахим сандаа бүртгэн авч, "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем" | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

96

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон “Төрийн мэдээлэл”, ”Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл” сэтгүүл, гар санг ашиглан иргэд, байгууллагад мэдээлэл, лавлагаагаар үйлчилж байна.<br>Мөн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Засаг даргын нийт 867 захирамжийг гарсан даруйд нь www.erdenet.mn сайтад байршуулсан.<br>Лавлагааны санг нийт 1349 эрх зүйн актаар шинээр баяжуулж, 318 зүйл заалтад нэмэлт өөрчлөлтийг тусган лавлагаа, мэдээллээр үйлчлэх ажлын бэлэн байдлыг хангаж ажиллалаа.<br>Лавлагааны сангаас хууль, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжаар нийт 39 байгууллага, 63 иргэнд гар болон цахим сангаас лавлагаа мэдээллээр үйлчилсэн байна. | | |
| **Зорилт 2. “НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГА, ЗАСАГ ДАРГА, БУСАД БАЙГУУЛЛАГАД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Аймгийн Засаг даргын шийдвэр болон аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр, дүрэм, журмын төсөл, захиргааны болон худалдан авах ажиллагааны гэрээний төслийг хянаж, санал дүгнэлт өгөх, хууль зүйд нийцүүлж гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах | хянаж санал өгсөн төслийн тоо | 8 | 15 | Аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулах 3 шийдвэр, төрийн байгууллагуудаас гаргаж буй 4 дүрэм журам, аймгийн Засаг даргаас гаргасан 13 захирамжийн хууль зүйн үндэслэлийг төслийн шатанд хянаж санал дүгнэлт өгч, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажил үйлчилгээний болон бусад нийт 21 гэрээг хянаж хуульд нийцүүлж гаргахад мэргэжлийн туслалцаа үзүүлсэн. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2.2.<br>Сумдын Засаг даргын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах | Шийдвэр болон зөрчлийг арилгуулсан тоо | 17 | 20 | 2023 онд Баян-Өндөр сумын Засаг даргын А/01-А/263, Б/02-Б/65, Жаргалант сумын Засаг даргын А/01-А/201, Б/01-Б/47 дугаар захирамж, нийт 576 захирамжийн хууль зүйн үндэслэл, эрх зүйн зүйн сургалт сурталчилгаа, авлигын эсрэг үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд зохион байгуулж буй ажил, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, дүнг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн.<br>Сумдын хууль зүйн асуудал хариуцсан ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгч хууль тогтоомж, гарын авлага материалаар хангаж, 2 удаагийн сургалтад хамруулсан.<br>Сумдын Засаг дарга нарыг хууль зүйн туслалцаа, мэдээллээр хангаж, шүүхийн шатанд байгаа хэргүүдийн шийдвэрлэлттэй танилцаж, тухай бүрт нь холбогдох зөвлөгөө, зөвлөмж өгч хамтран ажиллаж байна.<br>Сумдын Засаг дарга нарын 2023 оны захирамжийн хууль зүйн үндэслэлд хяналт шалгалт хийж давхардсан тоогоор 92 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгах хугацаатай мэдэгдэл хүргүүлж зөрчлийг бүрэн арилгуулсан. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |
| 3. | Арга хэмжээ 2.3.<br>Жаргалант сумын нотариатын үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах | үйл ажиллагаа хуульд нийцсэн байх | - | Арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан байна. | Жаргалант суманд нотариатын үүрэг гүйцэтгэгч ажилладаг бөгөөд удирдлага, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулж, ХЗДХЯ-аас цахимаар зохион байгуулсан 2 удаагийн сургалтад | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулсан. Холбогдох тайлан мэдээ, судалгааг хугацаанд нь хүргүүлж хяналт тавьж ажиллаж байна. Мөн Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Нотариатын салбар Зөвлөлийн дарга болон нотариатч нартай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний шуурхай байдлыг хангах иргэдийг чирэгдүүлэхгүй байх талаар санал солилцож, тодорхой шийдэл гаргаж хамтарч ажилласан. | | |
| 4. | Арга хэмжээ 2.4.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг тооцох, тайлагнах ажлыг хэрэгжүүлэх | Төлөвлөж хэрэгжүүлэн тогтоосон хугацаанд тайлагнасан байна. | 2 удаа | 3 удаа | “Аймгийн хэмжээнд авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г аймгийн Засаг даргаар батлуулан АТГ болон хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудад хүргүүлсэн ба хэрэгжилтийг тооцон төлөвлөгөөний биелэлт, хэрэгжүүлсэн ажлын тайланг АТГ-т тогтоосон хугацаанд хүргүүлж, www.erdenet.mn сайтад байршуулж тайлагнаж байна.<br>Аймгийн Засаг даргын дэргэдэх харьяа хэлтэс агентлаг, албадын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагаа, төлөвлөлт, ил тод байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан.<br>Төрийн албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 5 байгууллагад явуулж нийт 127 албан хаагч хамрагдсан. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | АТГ-аас ирүүлсэн 5 Зөвлөмжийг хэрэгжүүлж тайланг хүргүүлсэн. АТГ-аас орон нутагт ажиллах хөтөлбөрийн дагуу аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчид, ЗД-ын дэргэдэх агентлаг, хэлтэс, нэгж, алба болон төрийн болон ОНӨХК-уудын захирлуудад зохион байгуулсан сургалтыг хамтран зохион байгуулсан. | | |
| 5. | Арга хэмжээ 2.5. Хууль зүй, дотоод хэргийн сайд аймгийн Засаг даргын 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангахад хяналт тавих тайланг нэгтгэн гаргаж хүргүүлэх | Гэрээний хэрэгжилтийн хувь | 87 | Гэрээний хэрэгжилт 90 хувь | Хууль зүй, дотоод хэргийн сайд Орхон аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж гэрээний биелэлтийг ХЗДХЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт тусгуулж батлуулах, тендер шалгаруулахад шаардлагатай төсөв тооцоо, техникийн үзүүлэлтүүдийг бэлтгэж хүргүүлэх, тендерээр гүйцэтгэж байгаа ажилд хяналт тавих ажлыг хэрэгжүүлж, шаардлагатай нөхцөлд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд жилийн эцсийн гэрээний хэрэгжилт урьдчилсан дүнгээр 91.7 хувьтай байна. | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |
| **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, | хэрэгжилтийн хувь | 91 | тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлан, Хууль зүй дотоод хэргийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн тайлан, төрийн албан хаагчийн болон нэгжийн гүйцэтгэлийн | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | төлөвлөгөөний тайланг хэлтсийн хэмжээнд нэгтгэн гаргаж тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан. ЗДҮАХ-ийн биелэлт 94.2 хувь, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 100 хувь, ХЗДХСайдтай байгуулсан гэрээний урьдчилсан биелэлт 91.7 хувьтай тус тус үнэлэгдсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 3.2. Төрийн албаны тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй байх | - | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх | Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн холбогдох заалтууд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй болно. | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо | 21 | 23 | Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах төвийн 70353511 утсаар ирсэн 3, Засгийн газрын 1111 утсанд ирүүлсэн 3, бичгээр ирүүлсэн 20, нийт 26 өргөдөл гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг өгсөн. | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |
| 4. | Арга хэмжээ 3.4. Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, | Комисс, ажлын хэсэгт | 13 | 15 | Цагаатгалын ажлыг удирдан зохион байгуулах комисс, аймгийн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх | ажилласан тоо | | | гурван талт хороо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, орлогод нийцсэн орон сууцыг худалдан борлуулах ажлын хэсэг зэрэг 4 байнгын ажиллагаатай хороо, комисс, зөвлөлд гишүүнээр ажиллаж байна.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 9 ажлын хэсэг, 6 үнэлгээний хороо, ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан 3 комисс, ажлын хэсэгт ажиллаж өгөгдсөн үүрэг даалгавар, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлсэн. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн тоо | 17 | 20 | Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн болон удирдлагаас өгсөн 24 үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, и-оффис системд биелэлтийг оруулан тайлагнаж ажилласан. | 2024.01.01 - 2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1.<br>Удирдлагын академи, Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулж буй сургалтуудад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | 7 | Сургалтад хамрагдах | Төрийн албаны Зөвлөлөөс зохион байгуулж буй “7:4:10” арга зүйн 43 удаагийн сургалтад хамрагдсан.<br>Удирдлагын академиас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулсан “Дижитал хот” сэдэвт сургалтуудад хамрагдсан. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах | Сургалтууда д хамрагдсан байна. | 4 | Шинээр гарсан хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаанда а хэрэгжүүлэх, сургалтад хамрагдах | Шинээр гарсан болон шинэчлэн батлагдсан, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.<br>ЗГХЭГ-аас зохион байгуулсан 1, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2, аймгийн ИТХ-аас зохион байгуулсан 3, АЗДТГ-аас зохион байгуулсан 6 удаагийн сургалтад тус тус хамрагдсан.<br>Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ авсны дагуу Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан кредит багц тооцуулах сургалтуудад тухай бүр хамрагдсан. | 2024.01.01<br>-<br>2024.12.31 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН | Б.БАТТҮВШИН / ................... / | 2024.12.03 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |